АГУУЛГА

БҮЛЭГ 1. ОРШИЛ ... **3**
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... **4**
2.1. Төслийн нэр ... 4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч ... 4
2.3. Төслийн байршил ... 4
2.4. Хүчин чадал ... 6
2.5. Төслийн ерөнхий төлөвлөгөө ... 6
2.6. Төслийн хүчин чадал ... 6
2.7. Техник, тоног төхөөрөмж ... 6
2.8. Технологи ... 6
2.9. Түүхий эд, туслах материал, хог хаягдал ... 7
2.9.1. Ус хэрэглээ ... 7
2.9.2. Химийн бодисын хэрэглээ ... 7
2.10. Цахилгаан эрчим хүч ... 9
2.11. Дулаан хангамж ... 9
2.12. Зам харилцаа ... 9
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... **10**
3.1. Газрын гадарга, байр зүй ... 10
3.2. Уур амьсгалын онцлог ... 10
3.3. Усан орчин ... 11
3.4. Хөрс ... 11
3.5. Ургамал ... 11
3.6. Амьтан ... 11
3.7. Нийгэм эдийн засаг ... 12
БҮЛЭГ4.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ... **13**
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ... **14**
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... **17**
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ... 17
6.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ... 19
6.3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ... 20
6.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ... 20
6.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ... 22
6.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ... 23
6.7. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө ... 25
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ... 25
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ... **27**
НИЙТ ЗАРДАЛ ... **27**
ДҮГНЭЛТ ... **28**
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ ... **29**

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл 4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбилцол 4
Хүснэгт 3. Химийн бодисын жагсаалт 7
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 17
Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө 19
Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 20
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 22
Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 23
Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө 25
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 25
Хүснэгт 11. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал 27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Химийн бодисын агуулах”-ын байршлын зураг 5
Зураг 2. “Химийн бодисын агуулах”-ын харагдах байдал 5

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах”-ын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

“Химийн бодисын агуулах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“ Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах ” төслийн БОМТ-нд 2026 онд нийт 7,933,000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Айсмарк” ХХК
2	Регистрийн дугаар		5557747
3	Төслийн нэр		“Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах” төсөл
4	Төслийн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар хот
5		Сум/Дүүрэг	53329 м^2 Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 29-р хороо “Хөсөг трейд” ХХК-ийн “Үйлдвэрлэл үйлчилгээ”-ний зориулалттай газрыг түрээсийн гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байна.
7	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
8		Сум/Дүүрэг	Хан-уул дүүрэг
9		Баг/Хороо	29- хороо, 16/5 тоот
10	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал П. Ганчимэг
11		Гар утас	976-88880839

2.1. Төслийн нэр

“Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах” төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“АЙСМАРК” ХХК


2.3. Төслийн байршил

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 29-р хороо “Хөсөг трейд” ХХК-ийн “Үйлдвэрлэл үйлчилгээ”-ний зориулалттай газрыг түрээсийн гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байна.Тус талбайн булангийн цэгийн солбицолыг хүснэгтээр үзүүллээ**.**

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбилцол

№	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	51	0.16	47	54	0.15
2	106	51	0.01	47	54	0.02
3	106	50	55.82	47	54	1.32
4	106	50	55.2	47	54	1.53
5	106	50	54.05	47	54	1.55
6	106	50	53.82	47	54	3.2
7	106	50	53.73	47	54	3.46
8	106	50	53.59	47	54	5.02
9	106	50	53	51	54	5.41
10	106	50	52.06	47	54	5.3

11	106	50	49.02	47	54	5.12
12	106	50	48.7	47	54	6.98
13	106	50	48.91	47	54	7.59
14	106	50	49.06	47	54	7.62
15	106	50	52.88	47	54	6.78
16	106	50	54.98	47	54	10.15
17	106	50	59.75	47	54	48.9
18	106	51	4.09	47	54	7.8
19	106	51	3.79	47	54	7.32
20	106	51	3.48	47	54	6.74
21	106	51	3.53	47	54	6.74
22	106	51	3.37	47	54	6.51
23	106	51	3.17	47	54	6.22
24	106	51	3.12	47	54	6.1
25	106	51	3.4	47	54	5.99
26	106	51	2.59	47	54	4.65



Зураг 1. “Айсмарк зайрмагны үйлдвэрийн”-ын байршлын зураг



Зураг 2. “Айсмарк үйлдвэрийн ”-ын харагдах байдал

2.4. “Айсмарк” ХХК-ийн таницуулга

1996 оноос Бамбар хэмээх зайрмагийг үйлдвэрлэж одоогийн “Тэсо” групп компанийн эхлэлийг хамт хөлдөөсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дотоодын зах зээлийн 70 хувийг дангаар эзэмшдэг хүнсний манлай үйлдвэр “Айсмарк” компани өдгөө

28 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогоор 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэж байна. Манай компани олон улсын MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо, MNS ISO 22000:2019 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, MNS ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, MNS ISO 50001:2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо, MNS ISO 14001:2016 Байгаль орчны менежмент зэргийг дотооддоо нэвтрүүлсэн үйлдвэр юм. Мөн манай компани нь тогтвортой хамтын ажиллагааны хүрээнд Байгалийн цэвэр, органик түүхий эдүүдийг үйлдвэрлэлдээ ашигладаг "Айсмарк" компанийн хувьд 2000 гаруй малчдаас сүү, сүүн бүтээгдэхүүн, 500 гаруй тариаланчдаас байгалийн цэвэр жимс жимсгэнийг зах зээлийн ханшаар тогтмол худалдан авч тогтвортой орлогоор хангаж байна. Түүнчлэн “Айсмарк” компани ХБНГУ, ОХУ зэрэг улсуудтай 20 жилийн түншлэлийн харилцаатай байснаас үүдэн 2018 онд Нидерланд улсаас цагт 3000 ширхэг зайрмагийн шоколад үйлдвэрлэх бүрэн автомат тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж шоколадны

50 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэх болсон юм. Мөн сүүлийн найман жилд есөн аймагт хөргүүртэй агуулах барьж хөдөө орон нутгийн иргэдийг ажлын

байраар хангахаас гадна үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүйгээр хэрэглэгчдэд хүргэж байна.

Хүчин чадал

“Айсмарк” ХХК нь өөрслийн үйлдвэрлэлийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг Хятад болон Орос улсын баталгаат үйлдвэрт үйлдвэрлэсэн стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтой, битүүмжлэлтэй импортлон оруулж, химийн бодисын 6458:2014 стандартын шаардлага хангасан агуулахад хадгалан ашигладаг. Үйлдвэрийн хэмжээнд 400 гаруй ажилтан ажилладаг ба үүнээс 2 ажилтан /найрлагын оператор, эрүүл ахуйч/ тухайн агуулахыг хариуцан ажилладаг.

2.5. Төслийн ерөнхий төлөвлөгөө

Тус төсөлд ашиглагдах химийн бодисын агуулах нь стандартын шаардлагат хангасан нийт 55м^2 талбайтай, дулаан, цахилгаан нь төвийн шугам сүлжээнд холбогдсон, механик агааржуулалттай. Зохиомол гэрэлтүүлэгтэй, хана, шал нь химийн бодисоос үүссэн тоос, уур, манан тогтохооргүй материалаар хийгдсэн, люкс гэрэлтүүлэгтэй, агуулахад байвал зохих дохио үг, анхааруулах тэмдэглэгээ болон галын аюулын үед хэрэглэл, хэрэгсэлтэй, нэгдлүүдтэй харьцан ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа зөвлөмжүүдийг байршуулсан. Агуулах нь гадаад орчноос тусгаарлагдсан, нэвтрэх эрхтэй ажилчдаас өөр хүн нэвтрэх боломжгүй, гадаад талбай нь агуулахын эргэн тойрон бетонон цутгалттай зэргийг дурьдаж болно. Агуулахын гадаад болон дотоод нөхцлийг дараах зургуудаар баталгаажуулав.

2.6. Төслийн хүчин чадал

“Айсмарк” ХХК нь төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтын хүрээнд 11 төрлийн нийт 550.3 тн нэгдлүүдийг импортлон, хадгалж, ашиглахаар төлөвлөсөн байна. Мөн зайрмагны үйлдвэрлэл нь Хоногт 800,000-900,000 ширхэг (35,000-40,000 кг) зайрмаг үйлдвэрлэн борлуулдаг.

2.7. Техник, тоног төхөөрөмж

"Айсмарк" компанийн хувьд 2000 гаруй малчдаас сүү, сүүн бүтээгдэхүүн, 500 гаруй тариаланчдаас байгалийн цэвэр жимс жимсгэнийг зах зээлийн ханшаар тогтмол худалдан авч тогтвортой орлогоор хангаж байна. Түүнчлэн ХБНГУ, ОХУ зэрэг улсуудтай 20 жилийн түншлэлийн харилцаатай байснаас үүдэн 2018 онд Нидерланд улсаас цагт 3000 ширхэг зайрмагийн шоколад үйлдвэрлэх бүрэн автомат тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж шоколадны 50 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэж 1 цагт 5000-21000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий иж бүрэн 5 шугамтай. Бид Гаалиас өөрийн зориулалтын тээвэрлэгч байгууллагаар цэвэрлэгээний бодисыг авчирч агуулахад түр хадгална. Химийн бодисыг ачиж буулгах, ашиглахдаа ажилчдаа тусгай хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгч хамгаалах хувцас хэрэгслээр хангана.

2.8. Технологи

Химийн бодис тээвэрлэх, хадгалах технологийн үйл ажиллагааг дараахь байдлаар томёолж болох байна. Үүнд:

- Худалдан авах химийн бодисын захиалгыг Хятад болон Оросын талд

хүргүүлж төлбөр тооцоо хийх,

- Химийн бодисыг Монгол улсын хилээр оруулж ирсний дараа гаалийн бүрдүүлэлт хийж лабораторийн шинжилгээнд хамруулж дүгнэлт гаргуулах,
- Импортоор оруулж ирсэн химийн бодис, материалыг өөрийн агуулахад тээвэрлэн авчирч хадгалах,
- Химийн бодисыг захиалагч байгууллагад тээвэрлэн хүргэж борлуулалт хийх зэрэг болно.

2.9. Түүхий эд, туслах материал, хог хаягдал

2.9.1. Ус хэрэглээ

“Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах” төслийн үйл ажиллагааны хүрээнд ажилчдын унд ахуйн болон ахуйн зориулалтаар ус ашиглана. Тус ахуйн хэрэгцээний усыг төвийн шугамаар хангадаг. ***Үйлдвэрийн болон унд ахуйн усны хэрэглээ нийт:*** 3500 м3 ус ашиглаж байна. Үйлдвэрийн хэрэглээний усыг MNS 6561: 2024 стандартын шаардлагад нийцүүлэн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг.

2.9.2. Химийн бодисын хэрэглээ

Химийн бодисын агуулахад 11 нэр төрлийн химийн бодисуудыг хадгалах бөгөөд эдгээр бодисуудын 4 төрлийг ОХУ, БНХАУ-с импортох, 7 нэр төрлийг дотоодоос худалдан авахаар төлөвлөсөн байна. Жилд оруулж ирэх химийн бодисын нэр, төрөл, хэмжээг хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 3. Химийн бодисын жагсаалт

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Cas number	Хэмжээ /кг/ 1жил
1	Агааржуулагч бодис	Oasis compac 50 Ocean wave odor counteractant	68551-12-2	100
2	Задгай төхөөрөмжүүдийн ариутгалын бодис	Oasis compac quat sanitizer	68424-95-3 68424-85-1 64-17-5	400
3	Бактер устгагч үнэр дарагч	Mikro quat	68424-85-1 141-43-5 64-17-5	550
4	Гар ариутгагч бактергүйжүүлэгч саван	AB clean & smooth	110615-47-9 151-21-3 3380-34-5 7647-14-5	290
5	Азотын хүчил	Nitric acid	7697-37-2 7732-18-5	7200

6	Натрийн гидроксид	Sodium hydroxide	1310-73-2	6000

7	Шал угаагч	Торах-686	7681-52-9 1310-58-3 1643-20-5 37971-36-1	200
8	Тос задлагч	Oasis compac 10 heavy duty all purpose degreaser cleaner	141-43-5 1310-73-2	200
9	Кальцийн хлорид	Calcium chloride	10043-52-4	90000
10	Шал өнгөлөгч	Floor pro shine cleaner RM 755 ES	112-34-5 15763-76-5 67-63-0	120
11	Пероцууны хүчил	Peracetic acid	79-21-0	5000
Нийт /кг/				**110,060**
Нийт /тн/				**110.0**

2.10. Цахилгаан эрчим хүч

Нийслэлийн аж ахуй нэгж, ахуйн хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр Монгол улсын төвийн эрчим хүчнийг дунд голын цахилгаан дамжуулахаас дамжуулан хангагддаг. Нийт барилга байгууламж нь төвийн эрчим хүчний системд холбогдсон, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу цахилгаан эрчим хүчээ авдаг.

2.11. Дулаан хангамж

Агуулахын барилга нь Улаанбаатар хотын төвлөрсөн дулааны системд холбогдсон.

2.12. Зам харилцаа

ТЭЦ 4-ийн хатуу хучилттай замаар явна. Төслийн талбайн хатуу хучилттай замтай.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Газрын гадарга, байр зүй

Улаанбаатар хот нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт байрладаг байна.

МУ-ын нийслэл Улаанбаатар хот нь 1.3 сая хүн амтай. Улаанбаатар хот нийт 4,700 квадрат км (Монгол улсын нутаг дэвсгэрийн 0.3%) талбайтай бөгөөд 9 дүүрэгт хуваагдаж тэдгээр дүүрэг нь цаашдаа 152 дэд дүүрэг (*хороо*)[1] буюу хороо болж хуваагддаг. Хороо нь хэсгүүдээс бүрддэг.

Нийслэлийн хотын хамгийн өмнө захын цэг нь Төв аймгийн Сэргэлэн сумтай

хиллэж байгаа хойд өргөрөгийн $47^0$37’30”, зүүн уртрагийн $107^0$18’54”–ын солбицолд, баруун захын цэг нь Төв аймгийн Баянчандмань, Батсүмбэр сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн $107^0$23’12”, хойд өргөрөгийн $48^0$16’42”–ын солбицолд, хойд захын цэг нь Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн $48^0$16’00”, зүүн уртрагийн $106^0$27’–ын солбицолд, зүүн захын цэг нь Төв аймгийн Эрдэнэ сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн $107^0$37’24”, хойд өргөрөгийн $47^0$53’–ын солбицолд оршино.

3.2. Уур амьсгалын онцлог

Нарны цацраг: Төслийн район орших бүс нутаг нь уртрагийн дагуу сунаж тогтсон хойноос өмнө рүү цацраг, нарны гийгүүлэл нэмэгддэг зүй тогтолтой. Бүс нутагт дунджаар хэвтээ гадаргад 4686 мДж/м^2, шууд цацраг 2621 мДж/м^2 ирнэ. Нарны цацрагийн дулааны баланс жилдээ 1657 мДж/м^2 байх бөгөөд өвлийн саруудад -23 - -31 мДж/м^2 алдагдалтай, бусад саруудад эерэг илүүдэлтэй байна.

Агаарын температур: Эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөлөөс шалтгаалан өвөл нь харьцангуй хүйтэн, зундаа халуун байдаг. Сарын дундаж температур 1 дүгээр сард –27.4^{0}C ба 7 дугаар сард 17.1^{0}C байдаг. Хамгийн өндөр температур 7 дугаар сард 39^{0}C хүрч, 1 дүгээр сард -40^{0}C хүрч хүйтэрдэг байна.

Агаарын чийгшил: Төслийн талбайд жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр тохиолдож байхад 30-40 өдөр 80%-иас илүү их чийгтэй байдаг. Хур тунадас жилдээ 350-450мм, зарим жил үүнээс ч их, мөн зарим жил бүр бага ордог онцлогтой. Хур тунадасны 95-97% нь дулааны улиралд 75-80% нь зуны 3 сард ордог ерөнхий зүй тогтолтой. Хур бороoны хамгийн их эрчим 1.5мм/мин, дунджаар 0.02-0.04 мм хүрдэг нь усархаг бороотой гэсэн үг юм. Хур бороoны төрөл аадар, зүс, шиврээгээр ялгагддаг боловч 1км^2 талбайд 6-8 удаа аянга ниргэлт өгч, 30-40 өдөр аянгатай, 60-70 цаг үргэлжилж (max 130 цаг орчим) нэг аянга 105-230 минут үргэлжилнэ.

Салхи: Улаанбаатар хот орчимд салхины дундаж хурд 1.3-4.8 м/сек буюу 2.7 м/сек байдаг. Улирлын хувьд, салхины хурд хаврын улиралд 1.9-6.5 м/сек, өвлийн улиралд 0.7-2.8 м/сек, бусад улиралд 1.2-5.5 м/сек тус тус байдаг байна.

Хур тунадас: Чингэлтэй дүүрэгт сарын дундаж хур тунадас 296 мм ба 274 мм тус тус байдаг байна. Өндөр уулсын бүс нутагт хур тунадас 403 мм хүрдэг байна.

3.3. Усан орчин:

Гадаргын ус- Улаанбаатар хотын ус зүйн сүлжээг бүрдүүлэгч Туул гол, түүний цутгал голууд Хойд мөсөн далайн ай савд багтана.

Газрын доорх ус- Тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцөлийг илэрхийлж буй газрын доорхи усны тархалт, бүрэлдэн тогтолтын ерөнхий байдал болон геологийн тогтоцын өвөрмөц онцлогыг үндэслэн, судалгааны дэвсгэр талбайн хүрээнд гидрогеологийн давхарга зүйн хувьд дараах биеэ даасан уст үе давхарга, газрын доорхи усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна.

3.4. Хөрсөн бүрхэвч:

“Зайрмагны үйлдвэр”-ийн талбайд Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн дэд бүсийн хүрээнд Хэнтийн төвийн хөрсний тойрогт хамаарагдана (Үндэсний атлас, 2009). Агуулахын талбайд Сайр чулуурхаг хар хүрэн хөрс тархаж байна.

3.5. Ургамлан нөмрөг:

Улаанбаатар хот нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана (БНМАУ-ын үндэсний атлас, 1990 он).Төслийн талбайд Хялгана-хиаг-алаг өвст ургамлын бүлгэмдэл зонхилно. Ургамлан нөмрөг устаж үгүй болсон.

3.6. Агаар, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:

- Төсөл хэрэгжих хугацаанд тухайн агуулахад ирж буцах тээврийн хэрэгслийн тоо, тээвэрлэлт зэргээс тоосжилт үүсэх,
- Хорт утаа, хийн хаягдал,
- Тээврийн хэрэгслээс үүсэх дуу чимээ,
- Химийн бодис алдагдсанаас үүдэх агаар орчинд бохирдол бий болох, агаарт ууршилт үүсэх.

3.7. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө:

- Хүн, автомашины хөдөлгөөний улмаас хөрс элэгдэлд орох,
- Химийн бодисын алдагдал болон хог хаягдлаар хөрс бохирдох,
- Үйлдвэрлэлийн технологид хэрэглэгддэг химийн гаралтай бодисыг буулгах үед алдаж асгах тохиолдолд газрын хөрс бохирдох,

3.8. Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө:

- Химийн бодисыг хадгалах, тээвэрлэх явцад хадгалах саванд гэмтэл үүссэнээс шалтгаалж хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь,
- Химийн бодисын сав баглаа боодлын битүүмжлэл алдагдагдсанаас хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь,
- Тээвэрлэлтийн болон бусад үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчигдсөнөөс хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь.

3.9. Амьтан

Амьтны аймгийн хувьд Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрийн хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (P.domesticus) ба хээрийн (P.montanus) бор шувуу, хөхвөр тагтаа (C.livia), Сохор элээ (Milvus migrans), Шаазгай (Pica pica), Улаан хошуут (Pyrrhcorax pyrrhocorax), Хар хэрээ (Corvus corone), Хон хэрээ (Corvus corax) арай илүүтэй үзэгдэнэ. Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавьжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог тааралдана.

3.10. Нийгэм эдийн засаг

Нийслэлийн Баянгол дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нэг бөгөөд 2949 га газар нутагтай. Зүүн талаараа Чингэлтэй, Сүхбаатар, урд хэсгэрээ Хан-уул, баруун хойд талаараа Сонинохайрхан дүүрэгтэй хиллэдэг, газар нутгийн хэмжээ бага ч хүн ам ихээр төвлөрсөн дүүрэг юм.

Баянгол дүүрэг нь 2022 оны байдлаар 63.0 мянган өрх, 231.5 мянган хүн амтай. Газар нутгийн хэмжээ бага ч хүн амын төвлөрөл ихтэй. Мөн Баянгол дүүргийг залуусын дүүрэг гэж тодотгож болох бөгөөд дүүргийн нийт хүн амын 60.9 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг юм. Баянгол дүүрэг нь Засаг захиргааны анхан шатны нэгж болох 34 хороотой мөн 25 харьяа хэлтэстэй. Түүнчлэн дүүргийн нутаг дэсвгэрт 109 төсвийн байгууллага, долоон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Газрын гадарга, Хөрсөн бүрхэвч, Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгсэл болон хүний хөдөлгөөний улмаас хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх, үржил шимийн доройтолт орох,
- Химийн бодис асгарснаас газрын гадарга хөрс бохирдох,
- Тээврийн хэрэгслээс ШТМ асгарч хөрсний бохирдол үүсэх,
- Ахуйн хог хаягдлаар газрын гадарга, хөрс бохирдох,
- Үйлдвэр, агуулахын ургамлан бүрхэвч устаж үгүй болох, үйлдвэрээс гарах тоос нь орчны ургамлан бүрхэвчийн бүтцэд нөлөөлж улмаар доройтол үүсгэх.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт үүсэх,
- Салхитай үед агаарт тоосонцор үүсэх,
- Техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээний нөлөө үүсэх,
- Тээврийн хэрэгслийн яндангаас үүсэх утаа хий тортог гарах,

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Унд ахуйн усыг зориулалтын саванд хадгалаагүйгээс ус бохирдох,
- Ахуйн шингэн хаягдлаар хөрс бохирдох,
- Үер усны нөлөөлөл үүсэх,

Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Ахуйн хог хаягдал, бохир ус, бие засах газрын ашиглалтаас үүсэх орчны бохирдлын нөлөө,
- Хог хаягдлыг ил задгай хаяснаас үүсэх орчны бохирдол,
- Химийн бодисын сав баглаа боодлыг замбараагүй хаяснаас орчны бохирдол үүсэх.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсэх,
- Ажилчид хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллах,
- Ажилчид бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөхгүй байх,
- Химийн бодисонд хордож эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх,
- Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэхгүй байх.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Айсмарк” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

5.1. *Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт*

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усны чанарт усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

“Айсмарк” ХХК-ийн 2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

Зорилго: “Айсмарк” ХХК–ийн “Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах”-ын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “ Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах ”-ын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

5.2. ***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг, агуулга:***

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

БОМТ-г БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсруулсан.

5.3. ***Байгаль хамгаалах төлөвлөгөө:***

- Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
- Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн арга хэмжээ
- Тухайн жилийн БОМТ хэрэлжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ
- Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ
- Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

5.4. ***Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:***

- Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;

- Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм-жих нэгж	Нэгж-ийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын орчин									
1	-Агаарын бохирдол үүсэх, -Тээврийн хэрэгслийн яндангаас ууршилт, утаа, тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, - Химийн бодисын тээвэрлэлт хадгалалтын горим алдагдсанаар агаарт ууршилт үүсэх, -Зайрмагны үйлдвэрын ажиллагсад бодистой ажиллах үед хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх.	Агаарын тоосны (TSP,PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Үйлдвэрийн талбайд	ОХШХөтөлбөрт тусгагдсан				2026 онд	-Агаарын тухай хууль, -MNS 4585:2018 Агаарын чанар. Техникийн шаардлага, - MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт, -MNS 4990:2000 Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага, - MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн
2		Химийн бодис тээвэрлэх тээврийн хэрэгсэл, техникийг үзлэгт хамруулж, ялгарах хорт утаа, дуу чимээний түвшинг стандартад заасан хэмжээнд байлгах болон шатамхай, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бодис, бүтээгдэхүүнийг нэг дор хадгалахгүй байх.	Химийн бодис тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл	-	50.000	1	50.000	Тогтмол	
3			Химийн бодис	-	-	-	-	Тогтмол	

4		Зайрмагны үйлдвэрийн ажиллагсад бодистой ажиллах үед болон үйл ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын ууранр амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах	Ажилчид	-	-	-	-	Тогтмол	зөвшөөрөгдсөн концетраци. Техникийн ерөнхий шаардлага, -Химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах.

Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг									
1	-Химийн бодис тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх, -Химийн бодис хөрсөнд алдагдаж хөрс, ургамал бохирдох, -Тээврийн хэрэгслээр олон салаа зам гарган хөрс элэгдэл эвдрэлд өртөх.	Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх	Химийн бодис тээвэрлэх	-	-	-	-	2026 онд	-Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагуу д: MNS3298-91, -Хөрс-агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох: MNS3310-918, -MNS5850-2008, “ Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
2		Химийн бодис ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд сахих, хөрс бохирдсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах /элс, хайрга, даавуу, уусмал, хүрз, бээлий зэргийг бэлэн байлгах/.	Химийн бодис	-	800.000	1	800.000	2026 онд	
3		Үйлдвэрийн хашаанд тээврийн хэрэгслийг нэгдсэн нэг зам маршрутаар явуулах.	Тээврийн хэрэгсэл	-	-	-	-	Тогтмол	

Усан орчин									
1	- Усны хомдол, - Усны тэжээгдлийн мужийн давхцал.	Усны шинжилгээг тогтмол шинжлүүлж байх	Унд ахуйн ус, хаягдал ус	-	-	-	ОХШ-Хөтөлбөрт тусгагдсан	Улирал бүр	-Усны тухай хууль, -Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, - “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998
2		Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	Унд ахуйн ус	-	-	-	Ус ашиглах дүгнэлтэнд тусгагдсан	Жилд 1 удаа	
3		Хаягдал усны дүгнэлт гаргуулах	Хаягдал ус	-	-	-	Хаягдал усны дүгнэлтэнд тусгагдсан	Улирал бүр	
4		Тэжээгдлийн мужид газрын доорх усны түвшин, чанар, горимд байнгын ажиглалт хийх харуул, хяналтын цэгүүдийг тогтоох.	Усны тэжээгдлийн муж	Дотоод төлөвлөгөөгөөр				2026 онд	
5		Усны тэжээгдлийн мужийг "Эрүүл ахуйн хамгаалалтын бүс"-эд хамруулж, онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн заагийг албан ёсоор тогтоон, тэмдэгжүүлэх.		Дотоод төлөвлөгөөгөөр				2026 онд	
Нийт							850.000		

6.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн талбайн эргэн тойронд ногоон байгууламж бий болгох, арчилж, хамгаалах	Үйлдвэрийн хашаанд мод бут тарьж, ногоон байгууламж бий болгох	-	-	-	1,000,000	2026 онд	-MNS 6140:2010, Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага, -MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” -MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхи шаардлага” -MNS 5978:2008 “Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт”
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгаас тогтоосон газарт мод тарих	ш	100	-		2026 онд	
3	Мод бут, зүлэгжүүлэлтийн арчлалт хамгаалалт	Мод бут тарьсан газрыг арчлан хамгаалах, тордох, услаж байх.	-	-		575,000	2026 онд	
	Нийт					**1,575,000**		

6.3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Үйлдвэрийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй учир түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хийгдэхгүй.

6.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм-жих нэгж	Нэгж-ийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл галын гэнэтийн аюул үүсэх, -Химийн бодистой харьцах ажилчдыг сургалтанд хамруулаагүйгээс хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг	Галын аюулаас сэргийлэх анхааруулах санамж самбар хийж байршуулах	Үйлдвэр дотор	-	-	-	300.000	Тогтмол сайжруулах	-Гамшгаас хамгаалах тухай хууль, -MNS 6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо тодорхойлолт, ерөнхий анги. -Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль.
2		Үйлдвэр гал түймрийн үед хэрэглэх галын хор байршуулах	Үйлдвэр дотор	-	-	-	1.500,000	Тогтмол сайжруулах	
3		Химийн бодис асгарч алдагдах, ажиллагсад хордох, бэртэх гэмтэх, яаралтай тусламжийн эмийн санг бэлэн байлгах	Үйлдвэрт	-	-	-	100,000	ҮЙл ажиллагаа эхлэхийн өмнө	
4		Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллуулах	Ажилчид	-	-	-	-	Тогтмол	

	зөрчих, хордох, осол эрсдэл үүсэх,								
5		Ажиллагсдыг химийн бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Ажилчид	-	-	-	-	Тогтмол	
6		Химийн бодистой харьцаж буй жолооч ажилчдыг мэргэжлийн сургалтанд хамруулах, химийн бодисын хор аюулын мэдээлэл, бодистой ажиллах аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй болгох		-	-	-	300.000	Жил бүр	
7		Үйлдвэрт ажиллаж буй ажилчид нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас	Ажилчид	-	-	-	-	Тогтмол	

		урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх.							
Нийт							2,200,000		

6.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлын зориулалтын ангилан ялгах хогийн савыг сайжруулах, нэмэгдүүлэх.	Хог хаягдал	ш	150,000	1	1.850,000	2026 онд	Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль, Байгаль орчин, аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дугаар хамтарсан тушаалын “Химийн хорт болон аюултай бодисыг
2		Хогийг нэгдсэн нэг цэгт төвлөрүүлэх, Хог хаягдлын цэгийг хашаажуулах, гадна орчинд тархахаас сэргийлэх.	Хог хаягдал	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	
3	Үйлдвэрийн	Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж, хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах	Дахин ашиглах боломжтой хог хаягдал	-	-	-	-	Сар бүр	
5	Аюултай хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлын хатуу хог хаягдлуудыг зориулалтын агуулахад аюулгүйгээр цуглуулан хадгалж химийн хортой хаягдал устгах эрх бүхий тусгай аж ахуй нэгж рүү шилжүүлнэ.	Тэсрэх бодисын сав баглаа боодол	-	-	-	-	Тогтмол	

6		Химийн бодисын сав, баглаа, боодол болон хадгалах, ашиглах хугацаа дууссан буюу шаардлага хангахгүй болсон химийн бодис, мөн химийн бодис хэрэглэх үед ашиглаж байсан эд анги ашиглалтаас гарсан тохиолдолд саармагжуулж тусгайлан бэлдсэн агуулахад ангилан цуглуулж мэргэжлийн байгууллагаар устгуулах		-	-	-	“Түмэн эгшиг ” ХХК-тай гэрээ байгуулсны дагуу	2026 онд	хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 1 дүгээр хавсралт
		Нийт					**1.850.000**		

6.2. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцан хэрэгжүүлэгч	Зардал /төгрөг/ 2026 он	Шаардлага
1	Төсөл хэрэгжих хорооны удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Үйлдвэр	Жил бүр	“АЙСМАРК” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг байгаль орчныг төрийн захиргааны төв байгууллагаас авч ажиллах	Химийн бодис	2026-2027 онд	“АЙСМАРК” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 5, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15.6.3-р заалт
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг жил бүр батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийн тайланг жил бүр байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Зайрмагны үйлдвэр	Жил бүр	Байгаль орчны мэргэжилтэн	Дотоод төлөвлөлтөөр	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14.1.2-р заалт
4	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх /2 жил тутамд/	Зайрмагны үйлдвэр	2 жил тутамд 1 удаа	“АЙСМАРК” ХХК	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 10^1 зүйл
5	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, химийн бодисын менежментийн журам боловсруулах.	Ажилчид	Жил бүр	“АЙСМАРК” ХХК	Дотоод төлөвлөгөөгөөр	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 17-р зүйл, 13.2, 13.3-р зүйл.

6	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах	Ажилчид	Жил бүр	“АЙСМАРК” ХХК	1.000.000	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулна
Нийт					1.000.000	

6.3. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаанытов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Нийслэлийн байгаль орчны газарт	Тайлан хэлбэрээр, албан бичиг	БОМТ-ий хэрэгжилтийн талаар	11-р сард	-	“Айсмарк” ХХК	Нийслэлийн байгаль орчны газарт
2	БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчин бодлого зохицуулалтын газар	Тайлан хэлбэрээр, албан бичиг	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан болон тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	11 сард	-	“Айсмарк” ХХК	БОУАӨЯ

6.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байр-шил	Хугацаа ба давтамж	Давтам ж-ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал,төг /2026 он/	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын орчин								
1	Тоосжилт: / PM10, PM2.5, TSP / Агаарын бохирдол: / CO2, SO2, NO2 /	Үйлдвэр агуулахын орчмоос	Жилд 1 удаа	1 цэг	Агаарын шинжээч-100,000 Агаарын сорьц дээж-45,000	190,000	Агаарын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	-MNS 5885 : 2008, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага -MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашины, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга -MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга

Хөрсөн бүрхэвч								
2	-Хөрсний агрохими. / Нийт азот. Хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат гэх	Үйлдвэр агуулахын орчмоос 2 цэг	Жилд 1 удаа	2 цэг	Хөрсний агрохимийн шинжилгээ 1дээж-28,000	112,000	Итгэмжлэгдсэн хөрсний лабораторид шинжлүүлэх.	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс тодорхойлох арга -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний [illegible] тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
	-Хөрсний хүнд металл. / Кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр /	Үйлдвэр агуулахын орчмоос 1 цэг	Жилд 1 удаа	1 цэг	Хүнд металлын шинжилгээ 1дээж– 28.000	56,000		
Усан орчин								

1	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага: (Анионууд: Cl $SO4^{-}$, $NO2^{-}$, $NO3CO3^{--}$, $HCO3$ - Катионууд: $Na^{++}K^{+}$, Ca^{++}, Mg^{++}, $NH4^{+}$, Fe^{++}, Fe^{+++}, pH.	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	1 цэг				-MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага ,-MNS 13.060.50 Усны чанарын стандарт, -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
Нийт						**458,000**		

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Айсмарк” ХХК-ийн 2026 оны БОМТ-ний тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2026 онд БОМТ-нд нийт **7.933.000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 11. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Байгаль орчны төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг	Зардал /төгрөг/ 2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	850,000
2	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	1,575,000
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
4	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,200,000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,850,000
7	Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө	458,000
8	Оролцогч, сонирхогч тулуудад тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө	-
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,000,000
Нийт		**7.933.000**

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 29-р хороонд байрлах ”Айсмарк” ХХК-ийн “ Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодис импортлох, ашиглах, хадгалах ”-ын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг боловсрууллаа.

“Айсмарк ” ХХК-ийн 2026 оны БОМТ-ний тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 онд нийт 7.933.000 төг зарцуулахаар төлөвлөлөө.

“Айсмарк” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

“Айсмарк” ХХК нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж зэргийг дагаж мөрдөж ажиллах шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
6. Улаабаатар хотын Баянгол дүүрэгт байрлах “Айсмарк” ХХК-ийн “” Зайрмагны үйлдвэрийн цэвэрлэгээнд ашиглах химийн бодис импортлох, ашиглах, хадгалах ”-ын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2026 он
7. http://www.legalinfo.mn//
8. www.met.gov.mn
9. ArcGIS 10.5